

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ  
ТУХАЙ САНГИЙН ЯАМНЫ 1609 ДУГААР ГЭРЭЭНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭСЭН АКТ**

2019 оны 12 дугаар сарын 06

**1. ЕРӨНХИЙ ЗААЛТ**

Гэрээний нэр	Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх
Гэрээний дугаар:	СЯ1609
Захиалагч байгууллага	Сангийн яам
Захиалагч байгууллагын төлөөлөх эрх бүхий нэгж	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар
Гүйцэтгэгч байгууллага	Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн
Гэрээ сунгасан огноо:	2017 оны 12 дугаар сарын 15
Гэрээ дүгнэсэн огноо:	2019 оны 12 дугаар сарын 18

**2. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

**2.1. Гэрээний тусгай нөхцөлийн биелэлт**

Гэрээний нөхцөл	тусгай	Биелэлт	Биелэлт /хувиар/
Нэг.	НББ-ийн программын талаар	МНББХ-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №1	
1.1	“Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж нягтлан бодох бүртгэлийн программ нь СТОУС-т нийцсэн байдалд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор: А. НББ-ийн программ зохиогч компаниудаас боловсруулж Аж ахуйн нэгжид суурилуулсан программуудад үнэлгээ өгөх ажлыг хийж дуусгах Б. НББ-ийн программ зохиогч компаниудаас боловсруулж Төсөвт	Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд дүгнэлт гаргах ажлын хэсгийн удирдамж”-ийн 2.3-т заасны дагуу 22 компанийн нягтлан бодох бүртгэлийн программ нь олон улсын стандартад нийцсэн байдалд дүгнэлт гаргаж, холбогдох өргөдөл, программын дэлгэрэнгүй танилцуулга, аж ахуйн нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажиллагсдын жагсаалт зэрэг материалыг Сангийн яамны НБББ-ын газарт хүлээлгэн өгөөд байна. Үүнд: Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн 16 программ: 1. “Астериск Техноложис” ХХК-ийн ODERP-10.0; 2. “Вансифорус” ХХК-ийн 1С Enterprice; 3. “Прософт” ХХК-ийн Prosoft Account 4.0;	100%

<p>байгууллагуудад суурилуулсан программуудад үнэлгээ өгөх ажлыг хийж дуусгах</p>	<p>4. “Эн Эм Эм Эй” ХХК-ийн Эрхэт;  5. “Ултимэйт Солюшнс” ХХК-ийн Ultimate ERP;  6. “Апекс Софт” ХХК-ийн Апекс 2.18.65.167;  7. “Ординат” ХХК-ийн Юникус;  8. “Инфосистемс” ХХК-ийн Макс,ХЕ-3,  9. Интерактив ХХК VERITECH ERP 6.1  10.Интерактив БИ АЙ ХХК DAIMOND 5.0  11.Даянсофт ХХК DAYANSOFT ACCOUNTING  12. Дижитал воркс ХХК GREEN FINANCE  13. Межик клоуд ХХК MEGIC FINANCE  14. Интерсолюшинс Динамикс НАВ  15. Дайверс ХХК ОПТИМФЛЕКС 4.0  16. Барон ХХК Түшиг 6.0</p> <p>Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн 6 программ:</p> <p>1. “Ординат” ХХК-ийн Unucus 1.1;  2. “Гүүксофт” ХХК-ийн Ахplorer;  3. “Гүүксофт” ХХК-ийн Dynamic 1.0;  4. “Си Ти Эс” ХХК-ийн STSYSTEM 6.0.1;  5. ШУТИС-ын U-finance 3.0;  6. “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous 4.0</p> <p>Эдгээр 22 НББ-ийн программд үнэлгээ хийснээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа бүх компаниуд хамрагдсан болно.</p>	
<p>1.2 НББ-ийн программ зохиогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх:</p> <p>1) Татварын шинэ багц хуулиудын агуулгыг НББ-ийн программд тусгах асуудлаар Санхүүгийн ба татварын тайлангийн зөрүүгийн тайлангийн талаар</p>	<p>НББ-ийн программд дүгнэлт хийлгэхээр бүртгүүлсэн 22 компанийн ажилтнуудад тестийг хэрхэн бөглөх болон бодлого бодох талаар тус бүрд нь ганцаарчилсан зөвлөгөө өгөв.</p> <p>Мөн шалгагдсан программыг засаж сайжруулах талаар албан ёсоор дүгнэлт өгснийг хавсаргав.</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн программын боловсруулалтын одоогийн байдал, нийтлэг дутагдал болон цаашид хөгжүүлэхэд анхаарах асуудал, мөн Татварын багц хуулийг хэрэгжүүлэх журмуудыг НББ-ийн программд тусгах асуудлаар программ зохиогчдод 6 цагийн семинар зохион байгуулав</p>	<p>100%</p>
<p>2) НББ-ийн программ зохиогчдын зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн программын боловсруулалтын одоогийн байдал, нийтлэг дутагдал болон цаашид хөгжүүлэхэд анхаарах асуудал, мөн Татварын багц хуулийг хэрэгжүүлэх журмуудыг НББ-ийн программд тусгах асуудлаар СЯ, ХСНХ-той</p>	<p>95%</p>

хамтран зохион байгуулах	хамтран программ зохиогчдод 6 цагийн семинар зохион байгуулав	
Хоёр. Судалгаа шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах талаар	МНББХ-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №2	
2.1 Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх асуудлаар тодорхой чиглэлүүдээр хийсэн судалгаанд үндэслэн зөвлөмж боловсруулж Сангийн яаманд шилжүүлэх	Төсвийн байгууллагын нягтлан бодогчдын нийгмийн асуудал, цалин хөлсний талаар судалгааны асуулт гаргаж 102 нягтлан бодогчоос судалгаа авсан. Судалгаанд цэцэрлэгийн 52, ерөнхий боловсролын сургуулийн 28, аймаг, дүүргийн ЗДТГ, ИТХ-ын 6, эрүүл мэндийн 8, ОНӨААТҮГ-ын 5, хөдөө орон нутгийн 4 нягтлан бодогч оролцсон. Судалгааны дүнг нэгтгэн Сангийн яаманд дараах 4 баримт бичиг боловсруулан танилцуулаад байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн байгууллагын нягтлан бодогчдын цалинг нэмэгдүүлэх талаар зөвлөмж</li> <li>• Төсвийн байгууллагын нягтлан бодогчдын ур чадварын нэмэгдэл олгох журмын төсөл</li> <li>• Төсвийн байгууллагын нягтлан бодогчдын мэргэшлийн зэрэг олгох журмын төсөл</li> <li>• Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайдын хамтарсан тушаалын төсөл</li> </ul>	100%
Гурав. Мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар	МНББХ-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №3	
3.1 Ажиллаж байгаа нийт мэргэжлийн нягтлан бодогчдыг улсын бүртгэлд хамаруулахад дэмжлэг үзүүлэх талаар Сангийн яаманд асуудал боловсруулж оруулах	Ажиллаж байгаа нийт мэргэжлийн нягтлан бодогчдыг улсын бүртгэлд хамаруулахад дэмжлэг үзүүлэх талаар Сангийн яаманд асуудал боловсруулж оруулсан. Сангийн яамнаас 2019 оны эхээр Нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэгийг зохион байгуулсан бөгөөд түүний хүрээнд ажиллаж байгаа нягтлан бодогчдын судалгааг авсан. Энэ судалгааны дүнг манай хүрээлэнд шилжүүлээд байгаа болно.	100%
3.2 Ажиллаж байгаа нийт мэргэжлийн нягтлан бодогчдыг улсын бүртгэлд бүртгэх ажлыг үргэлжлүүлнэ	Ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдын талаар Сангийн яамны болон хүрээлэнд урьд авагдсан судалгааны дүнг нэгтгэн мэдээлэлийн сан байгуулах ажлыг хийгээд байна.	80%
3.3 Мэргэжлийн нягтлан	Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн	80%

бодогчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, ёс зүйн тангараг өргөх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ	талаар ХААИС, СЭЗИС, Мандах бүртгэл их сургуулийн төгсөх ангийн 200 гаруй оюутнуудад лекц уншиж соён гэгээрүүлэх ажил хийсэн.	
3.4 Мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн явцын талаар тайлан, мэдээлэлээр Сангийн яамыг хангаж, холбогдох арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ажиллах	Нягтлан бодогчдын ёс зүйн зөрчлийн асуудлаар ямар нэгэн гомдол, мэдээлэл ирээгүй болно	90%
	Дундаж хувь	92%

#### Хавсралт А—Үйлчилгээний тодорхойлолт болон хуваарь

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

#### Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт

<i>Үйлчилгээ</i>	<i>Үйлчилгээний төрөл</i>	<i>Үр дүн, чанар</i>
Үйлчилгээ 1	Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	НБОУХ-ноос батлан гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн стандартын агуулгад нийцүүлэн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулж батласан. Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчод ёс зүйн дүрмийг тайлбарлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх ажил зохион байгуулах, тэдний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт тавин ажиллаж байна
Үйлчилгээ 2	Аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх програм хангамж нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох	Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийж программ зохиодог 27 аж ахуйн нэгж байгааг бүртгэсэн болно.Тэдгээрээс 22 компанийн программыг шалгаж дүгнэлтийг Сангийн яаманд шилжүүлээд байна. Үлдсэн 5

	<p>бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол Улсын холбогдох заавар журамд нийцсэн эсэх талаарх мэдээллээр хангах;</p> <p>Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжид хяналт тавих;</p>	<p>компани программаа бүрэн бус байгаа тул ирэх жил шалгуулах хүсэлт гаргасан болно.</p> <p>Манай хүрээлэн ашиглагдаж байгаа програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа талаар дүгнэлт гаргасан.</p> <p>НББ-ийн зөвшөөрөгдсөн програм хангамжийн хэрэглээ, боловсруулалтын байдалд хяналт тавих, програмын чанар, үр дүнгийн талаар боловсруулагчидтай хамтран ажиллаж зөвлөмж бичиж өгч байгаа болно.</p>
Үйлчилгээ 3	<p>Санхүүгийн тайлагналын болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын нэвтрэлт, мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдал, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний чиглэлээр зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх.</p>	<p>Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар 2017 ба 2018 онд судалгаа хийх, зөвлөмж боловсруулж Сангийн яаманд өгсөн. Төсвийн байгууллагын нягтлан бодогчдын нийгмийн асуудал, цалин хөлсний талаар 2019 онд судалгаа хийж Сангийн яаманд зөвлөмж өгсөн Хавсралт 1</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн боловсруулалтын талаар судалгаа хийх, 22 компанид зөвлөмж өгсөн болно Хавсралт 2</p>
Үйлчилгээ 4	<p>Ажил эрхэлж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх.</p>	<p>Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээлэлийн сан байгуулах ажлыг хийж байгаа бөгөөд ойрын үед бэлэн болно.</p>

Энэхүү гэрээнд заасны дагуу Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн нь дараах хуваарийн дагуу үйл ажиллагаагаа гүйцэтгэнэ. Үүнд:

2019 оны Үйл ажиллагааны хуваарь

<i>Үйл ажиллагааны нэр төрөл</i>	<i>Хэрэгжилт</i>
Үйл ажиллагааны урьдчилсан тайлан, дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн хамт	Үйл ажиллагааны тайланг жил бүр эхний хагас болон бүтэн жилээр 2 удаа гаргаж Сангийн яаманд тайлагнаж дараагийн жилийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.
Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт	Дараа оны 2 сарын 1 дотор Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт тайлагнаж байгаа болно.
НБОУХ-ноос батлан гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн стандартын агуулгад нийцүүлэн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулж батлах, цаашид боловсронгуй болгох. Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчод ёс зүйн дүрмийг тайлбарлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх ажил зохион байгуулах, тэдний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих	НБОУХ-ноос батлан гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн стандартын агуулгад нийцүүлэн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг боловсруулж батласан бөгөөд түүнийг сурталчлах ажлыг гүйцэтгэж Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн талаар ХААИС, СЭЗИС, Мандах бүртгэл их сургуулийн төгсөх ангийн 200 гаруй оюутнуудад лекц уншиж соён гэгээрүүлэх ажил хийсэн.
Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийх.  Ашиглагдаж байгаа програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа талаар мэдээлэл бэлтгэх. НББ-ийн зөвшөөрөгдсөн програм хангамжийн хэрэглээ, боловсруулалтын байдалд хяналт тавих, програмын чанар, үр дүнгийн талаар боловсруулагчидтай хамтран ажиллах.	Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийж программ зохиодог 27 аж ахуйн нэгж байгааг бүртгэсэн болно.Тэдгээрээс 22 компанийн программыг шалгаж дүгнэлтийг Сангийн яаманд шилжүүлээд байна. Үлдсэн 5 компани программаа бүрэн бус байгаа тул ирэх жил шалгуулах хүсэлт гаргасан болно.  НББ-ийн программд дүгнэлт хийлгэхээр бүртгүүлсэн 22 компанийн ажилтнуудад тестийг хэрхэн бөглөх болон бодлого бодох талаар тус бүрд нь ганцаарчилсан зөвлөгөө өгөв. Мөн шалгагдсан программыг засаж сайжруулах талаар албан ёсоор дүгнэлт өгснийг хавсаргав.
Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах.	Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар 2017 ба 2018 онд судалгаа хийх, зөвлөмж боловсруулж

Мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдлын талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах	Сангийн яаманд өгсөн. Төсвийн байгууллагын нягтлан бодогчдын нийгмийн асуудал, цалин хөлсний талаар 2019 онд судалгаа хийж Сангийн яаманд зөвлөмж өгсөн Хавсралт 1 Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн боловсруулалтын талаар судалгаа хийх, 22 компанид зөвлөмж өгсөн болно Хавсралт 2
Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээлэлийн сан байгуулах, хэрэглэгчдэд мэдээлэх	Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээлэлийн сан байгуулах ажлыг хийж байна.

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн нь дүрмийн дагуу үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, эрх бүхий албан тушаалтан, ажилтныг сонгон шалгаруулах болон сонирхлын зөрчлөөс сэргийлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

#### **Хавсралт Б— Тайлагнах үүрэг хариуцлага**

Үйлчилгээ үзүүлэгч Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн ТББ нь тухайн жилийн үйл ажиллагааны тайланг дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн хамт тухайн оны 12 дугаар сарын 15-ний дотор; Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт дараа оны 2 дугаар сарын 01-ны дотор тус тус Захиалагч талд тайлагнаж байгаа болно.

#### **Хавсралт В—Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчин**

*В-1 Албан тушаал, ажлын дэлгэрэнгүй тодорхойлолт болон тухайн ажилтанд тавигдах хамгийн бага чадварын шаардлага.*

<i>Албан тушаал</i>	<i>Тавигдах шаардлага</i>	<i>Чухал шаардлага</i>	<i>Ур чадвар</i>
<b>Ажлын алба:</b>			
Тэргүүн	Дээд боловсролтой, эрдмийн зэрэгтэй	Баг бүрдүүлэн бусдыг манлайлдаг, удирдах ажлын туршлагатай байх	Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр туршлагатай, Судалгаа хийх, удирдах, Эрдэм шинжилгээний бүтээл гаргах, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах

			чадвартай
Гүйцэтгэх захирал	Дээд боловсролтой, гадаад хэлний мэдлэгтэй	Харилцааны ур чадвартай, нууц хадгалах, манлайлагч	Баг бүрдүүлэн ажиллах, эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх, бусдад урам хайрлах чадвартай, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Ерөнхий менежер	Дээд боловсролтой	Харилцааны ур чадвартай, манлайлагч, багаар ажиллах, баг удирдах чадвартай	Бусдад нөлөөлөх, бусдад урам хайрлах, баг бүрдүүлэн ажиллах. Эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргадаг, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Сургалтын менежер	Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх	Бусдыг манлайлах, компьютерийн өргөн хэрэглээний программууд дээр ажилладаг байх, илүү цагаар ажиллах, нууц хадгалах	Сургалтын хуваарь гаргах, сургалтад хичээл заах багш нарыг бэлтгүүлэх, багаар ажиллах чадвартай, санаачлагатай байх аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай,
Нягтлан бодогч	Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх	Компьютерийн өргөн хэрэглээний программууд дээр ажилладаг байх, илүү цагаар ажиллах, нууц хадгалах	Багаар ажиллах чадвартай, санаачлагатай байх, мэргэжлийн хичээл заах, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Мэдээлэл технологийн инженер	Дээд боловсролтой	Мэдээлэл технологийн болон компьютерийн эх бэлтгэлээр мэргэшсэн	Багаар ажиллах чадвартай, бүтээлч, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Гадаад харилцааны менежер	Дээд боловсролтой	Англи хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй	Удирдан манлайлагч, багаар ажиллах чадвартай, бүтээлч санаачлагатай байх
Судалгааны ажилтан	Дээд боловсролтой	Эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа хийдэг байх, гадаад	Бүтээлч санаачлагатай, дүгнэлт харьцуулалт хийдэг, бусдыг удирдаж



		хэлний зохих мэдлэгтэй	багаар ажиллах чадвартай байх, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай
Багш	Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх	Нягтлан бодох бүртгэл, Гааль-Татвар, Нийгмийн даатгал, Хуулийн чиглэлээр 3-с дээш жил ажилласан мэргэжлийн дадлага туршлагатай, багшлах эрхтэй байх	Бүтээлч, санаачлагатай, өөрийгөө хөгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах, аргачлал, заавар, зөвлөмж боловсруулах чадвартай

*В-2 Голлох мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага*

<i>Албан тушаал</i>	<i>Тавигдах шаардлага</i>
Удирдах Зөвлөл	Үүсгэн байгуулагчдын хурлаар Удирдах зөвлөлд сонгогдсон байх, Удирдах ажлын туршлага, багаар ажиллах, манлайлах,
Ажлын албадын дарга нар	Удирдан зохион байгуулан баг бүрдүүлж, манлайлан ажиллах чадвартай,

Тайлбар: В-1 Албан тушаал, ажлын дэлгэрэнгүй тодорхойлолт болон тухайн ажилтанд тавигдах хамгийн бага чадварын шаардлага, В-2 Голлох мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага бүрэн хэрэгжиж байгаа болно.

**Хавсралт Г— Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл**

<i>Үйлчилгээ</i>	<i>Үйлчилгээний төрөл</i>	<i>Техник хэрэгслэл</i>
Үйлчилгээ 1	Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчод ёс зүйн дүрмийг тайлбарлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх ажил зохион байгуулах, тэдний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих	1. Сургалтын түрээсийн анги танхим 2. Гарын авлага ном сурах бичиг
Үйлчилгээ 2	Аж ахуйн нэгж байгууллагад ашиглагдаж байгаа НББ-ийн програм хангамжийн талаар судалгаа хийх.  Ашиглагдаж байгаа програм хангамж нь СТОУС, УСНББОУС болон Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа талаар	3. Техник тоног төхөөрөмж, компьютер, програм хангамж шаардлагатай

	мэдээлэл бэлтгэх. НББ-ийн зөвшөөрөгдсөн програм хангамжийн хэрэглээ, боловсруулалтын байдалд хяналт тавих, програмын чанар, үр дүнгийн талаар боловсруулагчидтай хамтран ажиллах.	хэмжээгээр бэлэн байгаа.
Үйлчилгээ 3	Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийн талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах Мэргэжлийн нягтлан бодогчдын ажил эрхлэлтийн байдлын талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэглээний талаар судалгаа хийх, зөвлөмж боловсруулах, сургалт явуулах.	
Үйлчилгээ 4	Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын бүртгэл хөтлөх, мэдээлэлийн сан байгуулах, хэрэглэгчдэд мэдээлэх, ажилд зуучлах.	

Гэрээний хэрэгжилтийг шалгахад гарсан саналууд

<b>Сангийн яам</b>	
<b>Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн санал</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. НББ-ийн программ зохиогчдод гадаадын өндөр мэргэжлийн мэргэжилтэнг урьж ирүүлж 7-10 хоногийн сургалт зөвлөгөө өгүүлэх ажлыг донор байгууллага орнуудын тусламжаар гүйцэтгүүлэх</li> <li>2. Төсөвт байгууллагын НББ-ийн шинэчлэлтийн ажлыг түргэтгэх, УСНББОУС-ыг яаралтай орчуулах</li> </ol>

**ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН:**

Нийт нийлбэр дүнгээр гэрээний үүргийн биелэлт 92.0 хувь гэж хоёр тал харилцан тохиролцов.

**1. ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:**

**Захиалагчийг төлөөлж:**

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД  
Ч.ХҮРЭЛБААТАР



*Ч.Хурелбаатар*

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА:  
Ч.ЧИМДСҮРЭН

*Чимдсүрэн*

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН:  
Б.БОЛОРМАА

*Болормаа*

**Гүйцэтгэгч:**

МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:  
Л.ДОНДОГ



*Л.Дондог*

МОНГОЛЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР:  
Х.ДЭЛГЭРСАЙХАН

*Х.Дэлгэрсайхан*